



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 46

Есөнбулаг сум


**“Ногоон Алтай - Ногоон ажлын байр”  
төсөл батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ногоон Алтай - Ногоон ажлын байр” төслийг 1 дүгээр хавсралтаар, 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсвийн төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, 2017 оны үйл ажиллагааны төсвийн тооцосг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Ногоон Алтай - Ногоон ажлын байр” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

  
 ДАРГА Т.ГАНЗОРИГ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 05 дугаар сарын 22-ны  
өдрийн 29 дугаар тогтоолын  
1-р хавсралт

### “НОГООН АЛТАЙ-НОГООН АЖЛЫН БАЙР” төсөл

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Говь-Алтай аймаг нь 1940 онд байгуулагдсан бөгөөд хойд талаараа Завхан, зүүн талаараа Баянхонгор, баруун талаараа Ховд аймаг, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай тус тус хиллэдэг, засаг захиргааны 18 сум, 2 тосгонтой, 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутагт 16.3 мянган өрхөд 56.7 мянган хүн суурьшин амьдарч байгаагийн 49,7 хувь буюу 28,2 мянга нь эрэгтэйчүүд, 50,3 хувь буюу 28,5 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 30,2 хувь буюу 17,1 мянга нь аймгийн төв Алтай хотод, 25,2 хувь буюу 14,3 мянга нь сумын төвд, 1,6 хувь буюу 0,9 мянга нь тосгонд, 43,0 хувь буюу 24,4 мянга нь хөдөө амьдарч байна.

Аймгийн нийт хүн амын дотроос хөдөлмөрийн насны 36,4 мянган хүн, үүнээс ажиллагсад 25,1 мянга, ажилгүй 2,4 мянган хүнээс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа 786 хүн, үүнээс аймгийн төв Есөнбулаг сумд 326 иргэн буюу 41.4 хувийг эзэлж байна. Дээрх иргэдийн 67,1 хувь буюу 219 иргэн 6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажил олоход хүндрэлтэй иргэд байна. /Дэлгэрэнгүй судалгаа хавсралт-1/

Аймгийн нутаг дэвсгэр нь газрын дүрс мужлалын хувьд Алтайн уулархаг их муж, Говийн их мужид хамаарах бөгөөд байгалийн бүс, бүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэд оршдог. Өндөр уулын, хуурай хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Бас чийглэгдүү хүйтэн тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал хагас цөл нутаг хийгээд өндөр уулын оройн хэсэгт бүрэлдсэн тул хуурай, сэрүүвтэр болон гандуу дулаан зун хийгээд хахир, хахирдуу өвөл болдог. Хөрс газар зүйн мужлалтаар Төв Азийн говийн мужийн бүсшлийн Алтай хийгээд говийн тойргуудад багтдаг тул уулын болон талархаг ба хотгор газрын хөрс зонхилж байна. Иймээс ойн зурвас, ногоон төгөл байгуулах нь салхины хамгаалалт болоод зогсохгүй уур амьсгалыг зөөлрүүлж, эрүүл эко орчин бүрдүүлж, агаарын бохирдлыг багасгах, иргэдийн эрүүл, таатай орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм.

Аймгийн төв Есөнбулаг сум нь нийт 216133 га нутаг дэвсгэртэй, үүнээс Алтай хотын 5377 га нутагт 5340 мянган өрхийн 17,1 мянган хүн суурьшин амьдарч байна.

Алтай хотын нутаг дэвсгэрийн 130 орчим га газар ногоон байгууламж байгуулах боломжтой хэдий ч одоогийн байдлаар 14 га-д буюу 10,8 хувьд нь ногоон байгууламжийг байгуулсан байна. Цаашид 116 га-д ногоон байгууламж, ойн зурвас байгуулах боломжтой юм.

Иймд Аймгийн төв Есөнбулаг сумын Жаргалант толгойгоос Баарангийн даваа хүртэл 12 км газарт 10000-12000 ширхэг мод тарьж, ойн зурвас байгуулах шаардлагатай байна.

### **Хоёр. Төслийн зорилго**

Тус аймагт ойн зурвас байгуулж уур амьсгалыг зөөлрүүлэн салхины хамгаалалтыг бий болгон, эрүүл эко орчин бүрдүүлж, ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажлын байраар ханган орлогын дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

### **Гурав. Төслийн зорилтууд**

- 3.1 Ажилгүй иргэдийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.
- 3.2 Ажилгүй иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох идэвх санаачлагыг нэмэгдүүлнэ.
- 3.3 Удаан хугацаагаар ажилгүй байсан иргэдийг байнгын ажлын байраар хангаж орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.4 Ногоон төгөл байгуулж Алтай хотын өнгө үзэмжийг сайжруулан, эрүүл эко орчин бүрдүүлнэ.
- 3.5 Мод тарих, арчлах талаар мэргэжлийн зөвлөхийг ажиллуулж, туршлага судлах, сургалт зохион байгуулна.

### **Дөрөв. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

**4.1. Ажилгүй иргэдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилтын хүрээнд:**

- 4.1.1. Есөнбулаг сумын ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргана.
- 4.1.2. Ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээлнэ.
- 4.1.3. Есөнбулаг сумын ажилгүй 200 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулна.

**4.2. Ажилгүй иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох идэвх санаачлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

4.2.1 Орон нутгийн бүтээн байгуулалтад оролцож буй иргэдийн гүйцэтгэж байгаа ажлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан олон нийтийн анхаарлыг хандуулна.

4.2.2. Эрүүл эко орчинг хэрхэн бий болгох талаар “Ногоон-Алтай” хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилна.

4.2.3. “Ногоон-Алтай” төсөлд хамрагдах 30 иргэнийг “Мод тарих арга, аргачлал, усалгаа арчилгаа”-ны сургалтад хамруулна.

**4.3. Удаан хугацаагаар ажилгүй байсан иргэдийг байнгын ажлын байраар хангаж орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

4.3.1. Удаан хугацаагаар ажил хөдөлмөр эрхлээгүй 60 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, сард 240,0 мянган төгрөгийн урамшуулал олгон нийгмийн баталгааг нь хангана. /Жил бүрийн 5-11 сар/

4.3.2. Удаан хугацаагаар ажил хөдөлмөр эрхлээгүй 100 иргэнийг 10 хоногийн хугацаатай түр ажлын байраар ханган орлогын дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. Гадаад, дотоодын хандивлагч болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилгүй иргэдийг ажлын байраар хангана.

**4.4. Ногоон төгөл байгуулж Алтай хотын өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл эко орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

4.4.1. Есөнбулагийн сумын Жаргалант толгойгоос Баарангийн даваа хүртэл 12 км газарт 10000-12000 ширхэг мод тарьж ногоон төгөл байгуулна.

4.4.2. Дээрх газарт инженерийн хийцтэй гүний худаг 2 ширхэгийг гаргаж усалгааны асуудлыг шийдвэрлэнэ.

4.4.3. Ойн зурвас, ногоон төгөл байгуулсан талбайд хайс хамгаалалт хийж, харуул хамгаалалттай болгоно.

**4.5. Мод тарих, арчлах талаар мэргэжлийн зөвлөхийг ажиллуулж, туршлага судлах, сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд:**

4.5.1. Мод тарих, арчлах чиглэлээр мэргэшсэн зөвлөхийг урьж Алтай хотын байгаль цаг уур, экологийн онцлогт тохирсон түргэн ургацтай мод сонгоно.

4.5.2. Төслийн хүрээнд ажлын байраар хангагдаж байгаа иргэдэд ногоон байгууламж байгуулах чиглэлээр зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

### **Тав. Төслийн хугацаа**

5.1. Төслийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

#### **Зургаа. Төслийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

6.1. Аймгийн Засаг дарга төслийн хүрээнд зохион байгуулах ажилд зарцуулах хөрөнгийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.2. Төслийн хэрэгжилтийн хүрээнд мод тарих ажлыг мэргэжил арга зүйгээр хангах үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар хариуцана.

6.3. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь төсөлд хамрагдсан иргэдийг ажлын байраар хангах гэрээ байгуулж, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-т хүргүүлж, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд байнга хяналт тавьж төслийг хэрэгжүүлнэ.

#### **Долоо. Төслийн санхүүжилт**

7.1. Төслийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1. Төслийн нийт санхүүжилт 269,3 сая төг

А. Орон нутгийн төсвөөс /90,0 сая төг/

Б. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал /179,3 сая төг/

#### **Найм. Төслийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх**

8.1. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл, Нийгмийн бодлогын хэлтэс байнгын хяналт тавина.

8.2. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.

8.3. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

8.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар ажиллах хүчний асуудлыг хариуцан зохион байгуулна.

#### **Ес. Төслийн үр дүн, шалгуур үзүүлэлт**

9.1. Төсөлд хамрагдсан иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна.

9.2. Төсөлд хамрагдсан ажилгүй иргэдийн өрхийн орлого нэмэгдсэн байна.



9.3. Ажилгүй иргэдийн нийгэмд хандах хандлага, идэвх санаачлага дээшилсэн байна.

9.4. Төсөлд хамрагдсан иргэд ногоон байгууламж байгуулах талаар мэдлэг ур чадвартай болсон байна.

9.5. Есөнбулаг сумд ногоон төгөл байгуулж усалгааны асуудал бүрэн шийдэгдсэн байна.


9.6. Тарьсан мод 90 хувь ургасан байна.

9.7 Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах хэмжүүрээр үнэлнэ. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	2017	2018	2019	2020	Хэрэгжүүлэх байгууллага
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан иргэдийн тоо	200	100	100	100	ХХҮГазар
“Ойн аж ахуй, мод тарих, арчлах” сургалтад хамруулсан иргэдийн тоо	60		30		ХХҮГазар
Хөтөлбөрийг хүрээнд бий болсон ажлын байрны тоо	160	60	60	60	ХХҮГазар
Хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны тоо /ширхэг/	4000	4000	4000		ХХҮГазар, БОАЖГ
Хөтөлбөрийн хүрээнд байгуулсан худагны тоо	2				ХХҮГазар, БОАЖГ
Хайс хамгаалалтын хэмжээ	12 км				ХХҮГазар, БОАЖГ
Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байдал	2 дахин	2 дахин	2 дахин		ХХҮГазар, БОАЖГ

---o0o---

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
 2017 оны 05 дугаар сарын 22 -ны  
 өдрийн 14 дугаар тогтоолын  
 3-р хавсралт



**ТӨСЛИЙГ 2017-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2017.05.22

Алтай хот

Зорилт		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Хэрэгжүүлэх байгууллага	Шаардагдах төсөв	
			2017	2018	2019	2020		/ мянган төгрөгөөр /	
								Орон нутгийн төсвөөс	ХЭДСан бусад төсөл
Нэг. Ажилгүй иргэдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах	1	Есөнбулаг сумын ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргах					ХХҮГазар		
	2	Ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах, мэдээллийг сэргээх					ХХҮГазар		
	3	Ажилгүй иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх сургалтад хамруулах	200				ХХҮГазар		2000.0
Хоёр. Ажилгүй иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх	1	Орон нутгийн бүтээн байгуулалтад оролцож байгаа иргэд, гүйцэтгэж байгаа ажлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, олон нийтийн анхаарлыг хандуулах					ХХҮГазар		
	2	Эрүүл эко орчинг хэрхэн бий болгох талаар "Ногоон-Алтай" хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилах	250						2500.0
	3	"Ногоон-Алтай" төсөлд хамрагдах иргэдийг "Ойн аж ахуй, мод тарих, арчлах" сургалтад хамруулах	30				ХХҮГазар		2800.0

10

Гурав. Ажилгүй иргэдийг байнгын ажлын байраар хангаж орлогыг нь нэмэгдүүлэх	1	Удаан хугацаагаар ажил хөдөлмөр эрхлээгүй 60 иргэнийг байнгын ажлын байраар хангах /10 сар/	60	ХЭД Сан	ХЭД Сан	ХЭД Сан	ХХҮГазар		144000,0
	2	Удаан хугацаагаар ажил хөдөлмөр эрхлээгүй 100 иргэнийг түр ажлын байраар хангах /10 хоног/	100	ХЭД Сан	ХЭД Сан	ХЭД Сан	ХХҮГазар		28000,0
	3	Гадаад болон дотоодын хандивлагч байгууллагууд, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилгүй иргэдийг ажлын байраар хангана.					ХХҮГазар		
Дөрөв. Ногоон төгөл байгуулж Алтай хотын өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл эко орчин бүрдүүлэх	1	Есөнбулагийн сумын Жаргалант толгойгоос Баарангийн даваа хүртэл 12 км газарт 10000-12000 ширхэг мод тарьж ногоон төгөл байгуулах					ХХҮГазар	18000.0	
	2	Инженерийн хийцтэй гүний худаг 2-ыг гаргаж усалгааны асуудлыг шийдвэрлэх					ХХҮГазар	46000.0	
	3	Ойн зурвас, ногоон төгөл байгуулсан талбайд хайс хамгаалалт хийж, харуул хамгаалалттай болгох					ХХҮГазар	26000.0	
		<b>Нийт дүн</b>						<b>90000,0</b>	<b>179300,0</b>



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 05 дугаар сарын 22-ны  
өдрийн 26 дугаар тогтоолын  
3-р хавсралт

**"НОГООН-АЛТАЙ" төслийн үйл ажиллагааны төсвийн тооцоо /2017 он/**

№	Материалын нэр	хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Мод Улиас		12000	300.0	36000.0	
2	Худаг	ш	2	23000.0	46000.0	
3	Емкость 5т	ш	2	2500.0	5000.0	
4	Дуслын услалтын систем	ш	3	5000.0	15000.0	
5	Мотор	ш	2	2500.0	5000.0	
6	Хайс хамгаалалт	Шон	ш	8000	3.5	28000.0
7		Тор	24024 м 600 боодол	600	35.0	21000.0
8		Цемент	ш	200	13.0	2600.0
9		Боодлын төмөр утас	боодол 10	10	15.0	150.0
10	Зөвлөх	Байр	10 хоног 5 хүн	50	30.0	1500.0
11		Хоол				
12		Замын зардал	800 км 160л	1550	0.2	248.0
13		Ажлын хөлс	10 хоног 5 хүн	50	100.0	5000.0
14	<b>Дүн</b>				<b>165498.0</b>	
15	Ажиллах хүч	Түр ажлын байр	10 хоног	100	240.0	16800.0
16		Байнгын ажлын байр	7 сар	60	240.0	105600.0
17	Сургалт, сурталчилгаа	Мод тарих арчлах сургалт	10 хоног	60	53.4	2800.0
18		Зөвлөгөө мэдээлэл, сурталчилгаа				2000.0
19		"Ногоон-Алтай" хэлэлцүүлэг				2500.0
20	<b>Дүн</b>				<b>129700.0</b>	
<b>Нийт дүн</b>					<b>290298.0</b>	

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**